ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2023 оны 7 сар

2023.09.11

БАНКНЫ САЛБАРЫН ӨСӨЛТ

Банкны салбарын нийт активын хэмжээ сүүлийн 10 жилийн хугацаанд 3 дахин өссөн ба жилд дунджаар 15.8% өсжээ.

Хэвийн зээл 21.4 их наяд төгрөг хүрч нийт активын 44.6%-ийг бүрдүүлж байна. Харин хэвийн зээлийн дүн өмнөх сартай харьцуулахад 1.1 хувиар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.1 хувиар өссөн байна.

Аж ахуйн нэгж, иргэдийн харилцах өмнөх сартай харьцуулахад 6.5%-иар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.4%-иар өссөн байна. Харин нийт хадгаламж өмнөх сартай харьцуулахад 0.9%-иар буурсан, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2%-иар өссөн байна.

2022 он гарснаар бодлогын хүүг 6 удаа нэмж, 13%-д хүргэсэн нь хүүгийн түвшинг цаашид үргэлжлүүлэн өсгөх нь тодорхой боллоо.

(их наяд төгрөг)



(их наяд төгрөг)



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ЗЭЭЛИЙН ЧАНАР

2023 оны 7 сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн үлдэгдэл 25.1 их наяд төгрөг хүрч өмнөх сартай харьцуулахад 0.8%-иар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7%-иар өссөн байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 20%-ийг бөөний болон жижиглэн худалдааны салбар, 14%-ийг үл хөдлөх хөрөнгийн салбар тус тус эзэлж байна.

Харин банкны салбарын эрсдэлийг хэмжих гол үзүүлэлт болох чанаргүй зээлийн хувь 2023 оны 7 сарын байдлаар 8.8% хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 нэгж хувиар бага, өмнөх сартайгаа харьцуулахад 0.1 нэгж хувиар өндөр үзүүлэлт болж байна. Харин боловсруулах үйлдвэрийн салбарын чанаргүй зээлийн хэмжээ хамгийн өндөр буюу нийт чанаргүй зээлийн 20%-ийг эзэлж байна.

- Уул уурхайн салбар
- Барилгын салбар
- Үл хөдлөх хөрөнгийн салбар
- Боловсруулах үйлдвэрийн салбар
- Бөөний болон жижиглэн худалдааны салбар
- Бусад салбар

Чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ

Зээлийн хүү

Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллютень

Хадгаламжийн хүү

Эх сурвалж: Монгол Банк-Сарын бюллютень

Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 16.3% буюу өмнөх сарын түвшинд байгаа бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 нэгж хувиар өссөн байна.
Харин шинээр олгосон валютын зээлийн хүүгийн жигнэсэн дундаж нь 11.9% хүрч өмнөх сартай харьцуулахад 2.1 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 нэгж хувиар өссөн байна.

Шинээр татсан валютын хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 3.5% хүрч өмнөх сартай харьцуулахад 0.6 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 нэгж хувиар өссөн байна.
Харин шинээр татсан хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж нь 11.0% хүрч өмнөх сартай харьцуулахад 0.1 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 нэгж хувиар өссөн байна.

АШИГТ АЖИЛЛАГАА

2023 оны 7 сарын 31-ний өдрийн байдлаар нийт банкны салбарын өөрийн хөрөнгийн хэмжээ 5.6 их наяд төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 1.5%-иар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.7%-иар өссөн байна.
Тухайн оны ашиг, алдагдал 0.6 их наяд төгрөг хүрч өмнөх сартай харьцуулахад 12.4%-иар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.7%-иар өссөн байна.

2023 оны 7-р сарын 31-ний байдлаар банкны салбарын нийт хөрөнгийн өгөөж 2.2% байгаа нь өмнөх оны мөн үетэйгээ харьцуулахад 0.2 нэгж хувиар өссөн үзүүлэлт болж байна.
Харин өөрийн хөрөнгийн өгөөж нь 19.2% байгаа нь өмнөх оны мөн үетэйгээ харьцуулахад 2.2 нэгж хувиар буурсан үзүүлэлт болж байна.

Нийт хөрөнгийн өгөөж



Өөрийн хөрөнгийн өгөөж



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

2023 оны 7 сарын 31-ний өдрийн байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл 6.9 их наяд төгрөг хүрч өмнөх сартай харьцуулахад 0.3%-иар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.6%-иар өссөн байна. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 1.7%-ийг ипотекийн хугацаа хэтэрсэн зээл, 0.3%-ийг ипотекийн хэвийн бус зээл тус тус эзэлж байна.

Ипотекийн хугацаа хэтэрсэн зээл өмнөх сартай харьцуулахад 24.3%-иар өссөн бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 114.6%-иар өссөн байна.
Ипотекийн хэвийн бус зээл өмнөх сартай харьцуулахад 16.5%-иар буурсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.7%-иар өссөн байна.



110,590

Нийт зээлдэгчийн тоо

их наяд төгрөг

6.93

Нийт зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

БОДЛОГЫН ХҮҮ



Эх сурвалж: Монгол банк – Банкуудын нэгдсэн тайлан

Төв банкнаас арилжаалж буй хамгийн богино хугацаатай үнэт цаасны хүүг бодлогын хүү гэнэ. 2023 оны 3 сарын 15-ны өдөр Монголбанк гадаад эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг хэвээр хадгалах, хүүний коридорыг нарийсгах болон банкны гадаад зах зээлээс шинээр татсан 360 хоног хүртэлх хугацаатай эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох бодлогын шийдвэр гаргав. Энэхүү бодлогын арга хэмжээ нь төгрөгийн өгөөжийг хадгалах болон банкны гадаад валютын эх үүсвэр татах хөшүүргийг бий болгосноор эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах, улмаар инфляцыг зорилтот түвшин рүү илүү хурдан бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.

ХОЛБОО БАРИХ

С.ТҮВШИНЗАЯА
Дотоод зах зээл хариуцсан дэд захирал

+976 9912-2583
tuvshinzaya@tavanbogdcapital.com

А. ДОВДОННЯМ
Дотоод арилжааны менежер

+976 9400-4442
dovdonnyam.a@tavanbogdcapital.com

У.НОМИН
Шинжээч

+976 9400-0889
nomin.uu@tavanbogdcapital.com

Б.ОТГОН
Бондын брокер

+976 9510-2229
otgon.b@tavanbogdcapital.com

М.ХУЯГАА
Клерк

+976 9502-4664
khuyagaa.m@tavanbogdcapital.com

ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

БОЛОМЖОО БОДИТ БОЛГО

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭЛТЭС